

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20....оны.... сарын....-ны өдөр

Улаанбаатар хот

### **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**1994 оны 7 дугаар сарын 5-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20....оны.... сарын....-ны өдөр

Улаанбаатар хот

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ  
ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 2.1 дэх хэсгийн “Нийгмийн даатгалын тухай” гэснийг “Нийгмийн даатгалын ерөнхий,” гэж, “Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн” гэж, 6.4, 11.5, 13.3. дахь хэсгийн “ажилгүйдлийн тэтгэмжийн” гэснийг “тэтгэмжийн” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22.2 дахь заалтын “Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого бүрдүүлэх үйл ажиллагааг Нийгмийн даатгалын тухай хуулиар зохицуулна.” гэснийг, 23.2. дахь заалтын “Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлогоос төвлөрүүлсэн хөрөнгийг Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу зарцуулна.” гэснийг тус тус хассугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

20....оны.... сарын....-ны өдөр

Улаанбаатар хот

**ТЭТГЭМЖИЙН ДООД ХЭМЖЭЭ ТОГТООХ ТУХАЙ  
ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**2002 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр баталсан Тэтгэмжийн доод хэмжээ тогтоох тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ